



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2022
ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2023/03/НА-СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүү, нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ч.Болд
Утас: 260512 Цахим хаяг: boldch@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Бат-эрдэнэ
Утас: 261628 Цахим хаяг: Bat-ErdeneS@audit.gov.mn

Улаанбаатар хот
2023 он

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	13
3.4.1 Мөнгөн хөрөнгө	14
3.4.2 Авлага	14
3.4.3 Урьдчилгаа	15
3.4.4 Бараа материал	15
3.4.5 Үндсэн хөрөнгө	16
3.4.6 Өр төлбөр	17
3.4.7 Засгийн газрын хувь оролцоо	17
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	18
4. АУДИТЫН ТАЙЛАН	20
4.1 Ерөнхий зүйл	20
4.2 Материаллаг байдал	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	22
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	23
5.1 Харьяа байгууллагууд	23
5.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч	23
5.2.1 Албан шаардлага	23
5.2.2 Зөвлөмж	24
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	27
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	27
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	28
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	29



Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ЗГНХ	Засгийн Газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг Даргын нөөц хөрөнгө
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ХНХҮТ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХХҮХ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХУД	Хан-Уул дүүрэг



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Т.БАДРАХБАЯР ТАНАА

2023.03.24 № 01/609
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 1,414.4 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон 342.6 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.3, 22 дугаар зүйлийн 22.6.3, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.2.4, 31 дүгээр зүйлийн 31.1-д заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/134 дүгээр тушаалаар “Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсан” байна.

Аудитын гол асуудал

Засгийн газрын 2016 оны “Засгийн газрын агентлагийн орон тооны хязгаар батлах тухай” 4 дүгээр тогтоолоор баталсан орон тооны дээд хязгаарыг 10 орон тоогоор

хэтрүүлсэн зөрчлийг арилгах албан шаардлагыг 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгснийг хэрэгжүүлээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 24 зорилтын хүрээнд 98 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 92.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт үүнд хамааралгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САРАНСҮХ

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан


2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/ мянган төгрөгөөр/			
Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,543,483.5	2,053,818.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	42,861.6	68,548.3
33	АВЛАГА	820,706.3	492,830.4
34	УРЬДЧИЛГАА	13,000.0	13,000.0
35	БАРАА МАТЕРИАЛ	1,666,915.6	1,479,440.2
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	44,205,084.3	42,182,181.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	44,205,084.3	42,182,181.7
39200	Биет хөрөнгө	38,881,423.7	36,707,852.8
39300	Биет бус хөрөнгө	5,323,660.6	5,474,328.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	46,748,567.8	44,236,000.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	19,746.6	35,193.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	19,746.6	35,193.9
41300	Өглөг	19,746.6	35,193.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	46,728,821.3	44,200,806.6
51	Засгийн газрын хувь оролцоо	46,728,821.3	44,200,806.6
51100	Засгийн газрын оруулсан капитал	14,585,763.3	14,587,677.3
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	14,585,763.3	14,587,677.3
51200	Хуримтлагдсан үр дүн	26,021,913.4	23,515,477.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,121,144.5	6,097,651.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	46,748,567.8	44,236,000.5

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/			
Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	32,819,451.8	35,177,673.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,976,420.5	4,130,774.8
120	Нийтлэг татварын бус орлого	3,976,420.5	4,130,774.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	28,843,031.3	31,046,899.1
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	33,906,300.0	37,573,182.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	33,906,300.0	37,573,182.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,192,910.2	34,750,217.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	19,927,079.3	20,859,014.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,532,386.5	2,577,643.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,872,549.8	2,085,285.4
2104	Хангамж, бараа материалын зардал	858,007.8	848,112.2
2105	Нормативт зардал	434,977.9	803,623.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	94,336.6	135,663.5
2107	Томилолт, зочны зардал	26,036.8	99,847.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,073,523.7	2,510,175.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,374,011.8	4,830,852.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,713,389.8	2,822,964.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-1,086,848.2	-2,395,508.2
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0	65,980.5



Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	349,265.5	198,356.3
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-1,436,113.7	-2,527,884.0

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	48,097,113.3	0	48,097,113.3
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	78,705.8	0	78,705.8
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	48,175,819.1	0	48,175,819.1
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-10,884.1	0	-10,884.1
Тайлант үеийн үр дүн	-1,436,113.7	0	-1,436,113.7
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	46,728,821.3	0	46,728,821.3
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	21,448.0	0	21,448.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	46,750,269.3	0	46,750,269.3
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-23,492.7	0	-23,492.7
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,914.0	0	1,914.0
Тайлант үеийн үр дүн	-2,527,884.0	0	-2,527,884.0
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	44,200,806.6	0	44,200,806.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	30,461,259.7	33,760,921.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,149,184.3	2,299,083.2
120	Нийтлэг татварын бус орлого	1,149,184.3	2,299,083.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	29,312,075.4	31,461,838.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	30,335,373.9	33,619,402.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	30,335,373.9	33,619,402.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	27,193,225.4	30,794,996.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	19,854,657.8	20,844,891.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,537,019.4	2,500,307.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,874,644.3	2,084,106.7
2104	Хангамж, бараа материалын зардал	812,815.8	694,933.9
2105	Нормативт зардал	304,911.0	832,802.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	128,834.3	168,764.1
2107	Томилолт, зочны зардал	20,361.6	100,357.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,187,287.3	2,632,184.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	472,693.9	936,646.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,142,148.5	2,824,406.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	125,885.8	141,519.4

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	106,155.3	112,249.6
2200	Дотоод эх үүсвэрээр	106,155.3	112,249.6
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-106,155.3	-112,249.6
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-16,342.2	-3,583.2
14	Бусад эх үүсвэр	0	16,480.5
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	16,342.2	20,063.6
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	3,388.3	25,686.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	39,473.4	42,861.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	42,861.6	68,548.3

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	29,993,425,600.00	28,893,727,657.64	1,099,697,942.36	96.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	29,993,425,600.00	28,893,727,657.64	1,099,697,942.36	96.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	28,829,619,100.00	27,865,797,627.64	963,821,472.36	96.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	20,820,247,300.00	20,447,827,265.92	372,420,034.08	98.2
210101	Үндсэн цалин	14,375,933,900.00	14,007,869,819.98	368,064,080.02	97.4
210102	Нэмэгдэл	5,201,563,200.00	4,624,678,218.98	576,884,981.02	88.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,237,750,200.00	1,281,106,283.24	(43,356,083.24)	103.5
210104	Урамшуулал	5,000,000.00	534,172,943.72	(529,172,943.72)	10,683.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,519,419,000.00	2,460,007,198.45	59,411,801.55	97.6
210201	Тэтгэврийн даатгал	1,729,250,800.00	1,720,644,518.66	8,606,281.34	99.5
210202	Тэтгэмжийн даатгал	197,564,400.00	189,205,961.33	8,358,438.67	95.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	158,051,500.00	149,757,286.20	8,294,213.80	94.8
210204	Ажилгүйдлийн даатгал	39,613,200.00	37,369,675.24	2,243,524.76	94.3
210205	Эрүүл мэндийн даатгал	394,939,100.00	363,029,757.02	31,909,342.98	91.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,094,721,500.00	2,048,970,428.91	45,751,071.09	97.8
210301	Гэрэл, цахилгаан	275,039,300.00	308,566,687.05	-33,527,387.05	112.2
210302	Түлш, халаалт	930,252,600.00	882,202,602.32	48,049,997.68	94.8
210303	Цэвэр, бохир ус	162,124,000.00	144,918,251.64	17,205,748.36	89.4
210304	Байрны түрээс	727,305,600.00	713,282,887.90	14,022,712.10	98.1
2104	Хангамж, бараа материалын зардал	487,626,100.00	422,214,321.05	65,411,778.95	86.6
210401	Бичиг хэрэг	83,472,100.00	89,786,009.34	-6,313,909.34	107.6
210402	Тээвэр, шатахуун	124,417,400.00	103,290,112.80	21,127,287.20	83.0

**Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	120,900,500.00	89,287,946.26	31,612,553.74	73.9
210404	Ном, хэвлэл	1,080,000.00	50,000.00	1,030,000.00	4.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	16,859,500.00	10,268,186.00	6,591,314.00	60.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	140,896,600.00	129,532,066.65	11,364,533.35	91.9
2105	Нормативт зардал	888,346,000.00	799,926,526.70	88,419,473.30	90.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,987,000.00	11,670,213.60	7,316,786.40	61.5
210502	Хоол, хүнс	826,465,300.00	757,010,641.10	69,454,658.90	91.6
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	42,893,700.00	31,245,672.00	11,648,028.00	72.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	243,861,300.00	220,599,473.72	23,261,826.28	90.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	143,172,900.00	129,285,042.65	13,887,857.35	90.3
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,409,000.00	5,349,710.07	2,059,289.93	72.2
210604	Урсгал засвар	93,279,400.00	85,964,721.00	7,314,679.00	92.2
2107	Томилолт, зочны зардал	57,599,900.00	18,416,364.97	39,183,535.03	32.0
210702	Дотоод албан томилолт	51,099,900.00	12,721,164.97	38,378,735.03	24.9
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	6,500,000.00	5,695,200.00	804,800.00	87.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,664,207,000.00	1,424,132,968.68	240,074,031.32	85.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,354,576,000.00	1,144,449,250.17	210,126,749.83	84.5
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	124,131,400.00	122,125,100.00	2,006,300.00	98.4
210803	Даатгалын үйлчилгээ	79,493,500.00	71,048,363.46	8,445,136.54	89.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	13,681,600.00	11,628,982.90	2,052,617.10	85.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	3,150,700.00	2,123,650.00	1,027,050.00	67.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	55,274,700.00	45,116,885.30	10,157,814.70	81.6
210807	Газрын төлбөр	17,307,800.00	13,262,145.00	4,045,655.00	76.6
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	7,761,700.00	5,548,991.85	2,212,708.15	71.5
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	8,829,600.00	8,829,600.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,591,000.00	23,703,079.24	29,887,920.76	44.2


**Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,077,100.00	18,698,442.92	13,378,657.08	58.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,513,900.00	5,004,636.32	16,509,263.68	23.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,163,806,500.00	1,027,930,030.00	135,876,470.00	88.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,163,806,500.00	1,027,930,030.00	135,876,470.00	88.3
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,084,228,800.00	952,210,158.00	132,018,642.00	87.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	79,577,700.00	75,719,872.00	3,857,828.00	95.2
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	29,993,425,600.00	29,001,513,504.79	991,912,095.21	96.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	28,162,423,400.00	27,430,098,489.19	732,324,910.81	97.4
310001	Улсын төсвөөс санхүүжих	28,162,423,400.00	27,430,098,489.19	732,324,910.81	97.4
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,831,002,200.00	1,571,415,015.60	259,587,184.40	85.8
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	164,192,200.00	180,424,432.00	-16,232,232.00	109.9
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,666,810,000.00	1,390,990,583.60	275,819,416.40	83.5
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	3,296,076.30	-3,296,076.30	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	3,320.00	3,320.00	0.00	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	34	34	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	34	34	0.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,643.00	1,643.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	36	36	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	1,295.00	1,294.00	1.00	99.9
620003	Үйлчлэх ажилтан	312	313	-1.00	100.3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		3,407,130,721.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,392,822,421.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,008,228,593.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		397,064,653.87
210101	Үндсэн цалин		232,076,678.08
210102	Нэмэгдэл		24,804,885.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		10,263,630.50
210104	Урамшуулал		116,823,460.29
210105	Гэрээт ажлын хөлс		13,096,000.00



Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,300,443.89
210201	Тэтгэврийн даатгал	30,827,358.85
210202	Тэтгэмжийн даатгал	2,579,037.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,548,596.49
210204	Ажилгүйдлийн даатгал	272,390.51
210205	Эрүүл мэндийн даатгал	5,073,060.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,136,296.94
210301	Гэрэл, цахилгаан	4,427,508.94
210302	Түлш, халаалт	11,570,688.00
210303	Цэвэр, бохир ус	1,060,000.00
210304	Байрны түрээс	18,078,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	274,652,593.10
210401	Бичиг хэрэг	154,892,237.70
210402	Тээвэр, шатахуун	75,831,491.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,399,960.40
210404	Ном, хэвлэл	12,986,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,542,904.00
2105	Нормативт зардал	32,876,251.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	199,350.00
210502	Хоол, хүнс	31,917,901.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	759,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,661,420.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,625,000.00
210602	Тавилга	650,000.00
210604	Урсгал засвар	10,386,420.00
2107	Томилолт, зочны зардал	81,941,300.00
210702	Дотоод албан томилолт	81,941,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,226,173,691.59
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,167,495,387.59
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	630,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	38,304.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,230,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	55,780,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	895,421,943.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	828,492,443.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	66,929,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	384,593,827.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	194,101,967.80
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	146,351,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,828,210.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,922,357.80
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	190,491,859.87
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	114,236,981.29
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	33,625,465.76
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	42,629,412.82
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,308,300.00

**Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2200	Дотоод эх үүсвэрээр	14,308,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,308,300.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,407,130,721.56
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,407,130,721.56
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	327,215,414.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,345,410,543.96
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,222,572,065.60
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	511,932,698.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь холбогдох хууль тогтоомж, бодлого шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн салбарын зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулж, үйл ажиллагааны уялдаа холбоо, мэргэжлийн удирдлага арга зүйгээр хангах үүргийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн өмнө хүлээх чиг үүрэг бүхий Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Үйл ажиллагааны стратегийн мөн чанарыг “Хүн амын хөгжлийг хангах таатай орчныг бүрдүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх бодлого, арга хэмжээний хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, үйлчлүүлэгч төвтэй, мэргэшсэн чадварлаг, ёс зүйг дээдэлсэн манлайлагч байгууллага болно” гэж тодорхойлсон байна.

Тус байгууллагын тэргүүлэх чиглэл нь:

- Хүн амын хөдөлмөрлөх эрхийг хангах боломж, нөхцөлийг бүрдүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэх замаар зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ядуурлын түвшнийг бууруулах;
- Үндэсний хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйлчилгээний бодлогын хэрэгжилтийг дэлхийн жишигт хүргэн хөгжүүлэх;
- Төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй, тэгш шударга, чанартай хүргэх чадварыг байнга дэвшүүлсэн суралцагч байгууллагыг хөгжүүлэх, стратегийн төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын чадамжийг дээшлүүлэх;
- Байгууллагын гадаад, дотоод харилцааг хөгжүүлж, салбарын бодлогыг хэрэгжүүлэх, хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх талаар хамтран ажиллах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх;
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний цахим мэдээллийн нэгдсэн сүлжээг боловсронгуй болгож, төрийн зохих байгууллагуудын сүлжээ мэдээлэлтэй нэгдмэл байдлыг хангах.

Үйл ажиллагааныхаа эрхэм зорилгыг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлгийн хүн амд оновчтой хүргэх, чанар хүртээмж, үр ашгийг сайжруулах замаар амьжиргааны түвшнийг дээшлүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад оршино” гэж тодорхойлсон байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Монгол Улсын Үндсэн хууль, Захиргааны ерөнхий хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Ахмад настны тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль, Олон хүүхэд төрүүлж, өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль, бусад эрх зүйн актын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого, чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай”;
- Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол “Автомашин ашиглалтын тухай”;
- Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны А122/А-172 дугаар хамтарсан тушаалын хавсралт “Засгийн газар болон төсвийн байгууллагын дансыг банканд нээх, хаах, тайлагнах журам”;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар судалж, танилцсан бөгөөд дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ. Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого, чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил, гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,512.6 сая төгрөгөөр буюу 5.4 хувиар буурсан байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан
Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	42,861.7	68,548.3	25,686.7
Авлага	820,706.3	492,830.4	(327,876.0)
Урьдчилгаа	13,000.0	13,000.0	-
Бараа материал	1,666,915.6	1,479,440.2	(187,475.4)
Үндсэн хөрөнгө	44,205,084.3	42,182,181.7	(2,022,902.6)
Нийт хөрөнгө	46,748,567.8	44,236,000.5	(2,512,567.3)
Өр төлбөр	19,746.6	35,193.9	15,447.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	46,728,821.3	44,200,806.6	(2,528,014.7)
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	46,748,567.8	44,236,000.5	(2,512,567.3)

Эх сурвалж: ХХҮЕГ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад авлага, үндсэн хөрөнгө дансанд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 68.5 сая төгрөг болж, өмнөх оноос 25.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төгрөг	39,347.0	64,460.7	25,113.7
Төрийн сангийн харилцах	39,346.8	64,460.5	25,113.7
Арилжааны банк дахь харилцах	0.2	0.2	-
Гадаад валют	3,514.6	4,087.6	573.0
Арилжааны банк дахь харилцах	3,514.6	791.5	(2,723.1)
Замд яваа мөнгөн хөрөнгө		3,296.1	3,296.1
Дүн	42,861.6	68,548.3	25,686.7

Эх сурвалж: ХХҮЕГ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 64.5 сая төгрөг төрийн сангийн харилцах дансанд, 0.2 сая төгрөг арилжааны банк дахь төгрөгийн харилцахад, 0.8 сая төгрөг гадаад валютын харилцахад, 3.3 сая төгрөг нь замд яваа мөнгөн хөрөнгө байна. Төрийн сангийн харилцах дансанд харьяа 9 газрын Ахмадын сангийн үлдэгдэл, замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд БНСУ дахь ХНХҮТ-ийн төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгө тус тус бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт

- Бараа, ажил, үйлчилгээний төлбөрийг гүйцэтгэхдээ 124.4 сая төгрөгийн цахим и-баримтыг бүрдүүлээгүй /Багахангай дүүргийн ХХҮХ 3.4 сая, Багануур дүүргийн ХХҮХ 2.0 сая, Баянгол дүүргийн ХХҮХ 2.1 сая, Сэлэнгэ аймгийн ХХҮГ 6.4 сая, Дорноговь аймгийн ХХҮГ 110.1 сая, Орхон аймгийн ХХҮГ 0.4 сая/

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 492.8 сая төгрөг болж, өмнөх оноос 327.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбогдсон авлага	9,640.3	6,926.7	(2,713.60)
Төлбөртэй үйлчилгээний авлага	165.0	329.0	164.00
Татаас, санхүүжилтийн авлага	420,310.7	2,304.0	(418,006.70)
Байгууллагаас авах авлага	132,014.4	184,121.3	52,106.90
Хувь хүмүүсээс авах авлага	258,576.0	299,149.4	40,573.40
Дүн	820,706.4	492,830.4	(327,876.00)

Эх сурвалж: ХХҮЕГ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэл өмнөх оноос буурсан нь татаас санхүүжилтийн авлага барагдсантай холбоотой байна. Авлагын дансны үлдэгдэлд БНСУ дахь ХНХҮТ-ийн ажилтнуудын байрны барьцааны авлага 446.0 сая, ХХҮЕГ-ын Сангийн яамнаас авах татаас санхүүжилтийн 7.6 сая, ажиллагсдаас авах 12.9 сая, бусад харьяа газрын 26.2 сая төгрөгийн байгууллага болон хувь хүмүүсээс авах авлага тус тус бүртгэлтэй байна.

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 13.0 сая төгрөг болж, өмнөх оноос өөрчлөлт ороогүй байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	13,000.0	13,000.0	0.0
Дүн	13,000.0	13,000.0	0.0

Эх сурвалж: ХХҮЕГ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд Өмнөговь аймгийн ХХҮГ-ын өмнөх шилжин ирсэн 13.0 сая төгрөгийн худалдан авалтын төлбөр бүртгэлтэй байна.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 1,479.5 сая төгрөг болж, өмнөх оноос 187.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	46,711.5	49,496.3	2,784.8
Тусгай зориулалттай материал	42,278.2	45,587.9	3,309.7
Эм боох материал	4,433.3	3,908.4	(524.9)
Бэлэн бүтээгдэхүүн	19,835.8	18,933.3	(902.5)
Хангамжийн материал	1,566,803.3	1,374,435.6	(192,367.7)
Бичиг хэргийн материал	101,162.4	100,694.3	(468.1)
Аж ахуйн материал	588,815.1	600,379.1	11,564.0
Сэлбэг хэрэгсэл	56,669.2	47,791.5	(8,877.7)
Түлш, шатах тослох материал	60,495.5	27,173.6	(33,321.9)
Барилгын засварын материал	7,720.3	3,424.5	(4,295.8)
Хүнсний материал	6,034.6	21,181.3	15,146.7
Бусад хангамжийн материал	745,906.2	573,791.3	(172,114.9)
Мал амьтад	33,565.0	36,575.0	3,010.0

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дүн	1,666,915.6	1,479,440.2	(187,475.4)
-----	-------------	-------------	-------------

Эх сурвалж: ХХҮЕГ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 187.5 сая төгрөгөөр буурахад бусад хангамжийн материал 172.1 сая, түлш, шатах тослох материалын үлдэгдэл 33.3 сая төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Бараа материалын тодруулга тайлангаар худалдан авсан 1,850.7 сая, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 133.0 сая, данс хооронд шилжүүлэн бүртгэсэн 16.9 сая төгрөг, нийт 2,000.6 сая төгрөгөөр бараа материал нэмэгдэж, үйл ажиллагаанд зарцуулсан 2,077.4 сая, үнэ төлбөргүй шилжүүлсэн 34.4 сая, данс хооронд шилжүүлэн бүртгэсэн 76.3 сая төгрөг зэрэг нийт 2,188.1 сая төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт

- Нийслэлийн ХХҮГ нь байгууллагын даргын зөвшөөрөлгүйгээр 1.0 сая төгрөгийн бараа материалыг данснаас хассан;
- Баянгол дүүргийн ХХҮХ нь бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 2.9 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн;
- Говь-Алтай аймгийн ХХҮГ нь санхүүгийн тайлангаарх үлдэгдлээс нярвын тайлангаарх бараа материалын үлдэгдэл 5.1 сая төгрөгөөр зөрүүтэй.

3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 42,182.2 сая төгрөг болж, өмнөх оноос 2,022.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	38,881,423.8	36,707,852.8	(2,173,571.0)
Барилга, байгууламж, орон сууц	32,830,403.7	31,704,209.2	(1,126,194.5)
Авто-тээврийн хэрэгсэл	333,605.5	350,868.9	17,263.4
Машин тоног төхөөрөмж(компьютер)	3,782,193.0	2,953,290.4	(828,902.6)
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,460,402.7	1,236,843.9	(223,558.8)
Бусад үндсэн хөрөнгө	471,939.1	449,731.6	(22,207.5)
Дуусаагүй барилга, байгууламж	-	11,271.4	11,271.4
Ном	2,879.8	1,637.4	(1,242.4)
Биет бус хөрөнгө	5,323,660.5	5,474,328.9	150,668.4
Программ хангамж	945,039.8	1,023,544.9	78,505.0
Бусад биет бус хөрөнгө	4,378,620.7	4,450,784.1	72,163.4
Дүн	44,205,084.3	42,182,181.7	(2,022,903.0)

Эх сурвалж: ХХҮЕГ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тодруулга тайлангаар төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 112.2 сая, хандив тусламжаар 811.7 сая, дээд шатны болон бусад байгууллагаас балансаас баланст шилжүүлэн авсан 342.5 сая, бүтцийн өөрчлөлтөөр бусад байгууллагаас шилжүүлэн авсан 655.4 сая, дахин үнэлгээгээр нэмэгдсэн 8.8 сая, данс хооронд шилжүүлэн бүртгэсэн 404.7 сая, нийт 2,335.3 сая төгрөгөөр нэмэгдэж, ТӨБЗГ-ын шийдвэрээр акталж данснаас хассан 958.5 сая, худалдан борлуулсан 5.1 сая, балансаас баланст шилжүүлсэн 601.2 сая, дахин үнэлгээний хорогдол 181.4 сая, данс хооронд шилжүүлэн бүртгэсэн 347.4 сая, нийт 2,093.6 сая төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

- Налайх дүүргийн ХХҮХ-т элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 9.1 сая төгрөгийн хөрөнгийг цаашид ашиглах хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг боловсруулж, ТӨБЗГ-т хүргүүлээгүй;
- Баянгол дүүргийн ХХҮХ нь ТӨБЗГ-ын шийдвэргүйгээр 1.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгасан;
- Дорноговь аймгийн ХХҮГ-ын үндсэн хөрөнгийн дансанд биетээр оршин байхгүй 23.2 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 7.4 сая төгрөгөөр илүү, 1.7 сая төгрөгөөр дутуу тооцсон.

3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 35.2 сая төгрөг болж, өмнөх оноос 15.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	10,038.1	3,278.9	(6,759.2)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	4,754.1	4,754.1
Байгууллагад төлөх өглөг	8,569.7	11,908.1	3,338.4
Хувь хүмүүст төлөх өглөг	1,138.8	15,252.8	14,114.0
Дүн	19,746.6	35,193.9	15,447.3

Эх сурвалж: ХХҮЕГ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Ажиллагсадтай холбоотой өр төлбөрийн үлдэгдэлд НДШ-ийн 0.4 сая, ХХОАТ-ын 2.8 сая төгрөгийн өглөг;

Бараа үйлчилгээний зардлын өр төлбөрийн үлдэгдэлд 4.7 сая төгрөгийн түлш халаалтын зардалтай холбоотой үүссэн өглөг;

Байгууллагад төлөх өр төлбөрийн үлдэгдэлд ХУД-ийн ХХҮХ-ийн аудит баталгаажуулах зардлын 11.5 сая, бусад зардлын тооцооны 0.4 сая төгрөгийн өглөг;

Хувь хүмүүст төлөх өр төлбөрийн үлдэгдэлд ХХҮЕГ-ын БНСУ руу гэрээгээр явах иргэдийн илүү төлсөн хураамжийн 12.9 сая, харьяа 3 байгууллагын хувь хүмүүст төлөх 2.4 сая төгрөгийн өглөг тус тус бүртгэлтэй байна.

3.4.7 Засгийн газрын хувь оролцоо


Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 44,200.8 сая төгрөг болж, өмнөх оноос 2,528.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	14,585,763.30	14,587,677.3	1,914.0
Хуримтлагдсан үр дүн	26,021,913.50	23,515,477.5	(2,506,436.0)
Өмнөх үеийн үр дүн	27,458,027.20	26,043,361.5	(1,414,665.7)
Тайлант үеийн үр дүн	(1,436,113.70)	(2,527,884.0)	(1,091,770.3)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,121,144.50	6,097,651.8	(23,492.7)
Дүн	46,728,821.30	44,200,806.6	(2,528,014.7)

Эх сурвалж: ХХҮЕГ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал дансны үлдэгдэл 1.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Хөвсгөл аймгийн ХХҮГ 957 м.кв эзэмших эрхтэй газрыг дахин үнэлж, зөрүүг бүртгэсэн байна.



Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 23.5 сая төгрөгөөр буурсан нь харьяа газруудын данснаас хассан үндсэн хөрөнгийн зөрүүг хасаж бүртгэсэнтэй холбоотой байна.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 2,506.4 сая төгрөгөөр буурсан нь тайлант жилийн үр дүн 2,527.9 сая төгрөгөөр буурч, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт 21.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 32,741.2 сая, үйл ажиллагааны орлогоос 1,966.3 сая, нийт зарлагыг 34,707.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн төслийн саналаас үндсэн үйл ажиллагааны зардлыг 3,723.4 сая, бусад арга хэмжээний зардлыг 393.6 сая төгрөгөөр бууруулж, 30,590.5 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь цалин, НДШ, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг өндрөөр төлөвлөсөнтэй холбоотой байна.

3.5.2 Улсын төсвийн орлого бүрдүүлэлт

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд зааснаар 605.6 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх төлөвлөгөө баталснаас 674.6 сая төгрөг бүрдүүлж, улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

3.5.3 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийг тодотгож, баталсан төсвийг 597.1 сая төгрөгөөр бууруулсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 28,162.4 сая төгрөгийг улсын төсвөөс, 1,831.0 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 28,054.7 сая төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлогоор 1,571.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 28,893.7 сая төгрөг буюу 96.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагаа зардлын төсвийг 577.4 сая, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардал 360.8 сая, бусад арга хэмжээний зардал 153.0 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71902	Нийгмийн халамж	24,739,028.1	23,968,043.2	770,984.9	96.9
80101	Үндсэн үйл ажиллагаа	20,757,965.3	20,500,787.9	257,177.4	98.8
80102	Туслах үйл ажиллагаа	595,816.0	582,605.4	13,210.6	97.8
80103	Гэрээгээр гүйцэтгэх ажил, үйлчилгээ	1,801,160.0	1,440,383.3	360,776.7	80.0
80205	Мэдээлэл сурталчилгааны зардал	1,757.1	1,757.1	-	100.0
80218	Улс орноо гадаадад сурталчилах	1,043.6	1,043.6	-	100.0
80220	Холбооны суваг ашигласны хөлс	201,733.3	201,733.3	-	100.0
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	215,746.3	211,695.9	4,050.4	98.1

**Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	1,163,806.5	1,028,036.7	135,769.8	88.3
72102	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	5,254,397.5	4,925,684.4	328,713.1	93.7
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	5,254,397.5	4,925,684.4	328,713.1	93.7
	Нийт дүн	29,993,425.6	28,893,727.7	1,099,697.9	96.3

Эх сурвалж: ХХҮЕГ-ын 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын илрүүлэлт:

- Говь-Алтай аймгийн ХХҮГ нь тээвэр шатахуун болон бичиг хэргийн зардлыг 3.1 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин 5.7 сая төгрөгийн шаанал, урамшуулал олгосон;
- Дорнод аймгийн ХХҮГ сахилгын шийтгэлтэй 2 албан хаагчид 2.5 сая төгрөгийн урамшуулал олгосон;
- Орхон аймгийн ХХҮГ 2.6 сая, Дархан-Уул аймгийн ХХҮГ 3.6 сая төгрөгийн зардлыг төсөвт зохицуулалт хийх зөвшөөрөлгүйгээр зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан;
- Дархан-Уул аймгийн ХХҮГ үр дүнгийн урамшуулалт цалинг 1.1 сая төгрөгөөр илүү тооцож олгосон.

3.5.4 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрийг Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаар 327.2 сая, ЗГНХ, ЗДНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан 1,345.4 сая, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт туссан хөрөнгөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан 1,222.6 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 511.9 сая, нийт 3,407.1 сая төгрөгөөр бүрдүүлж, урсгал зардалд 3,392.8 сая, хөрөнгийн зардалд 14.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бараа материалын орлого, зарлагын гүйлгээг анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв бүртгэх, үндсэн хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв гүйцэтгэх, биет бус хөрөнгийн ашиглалт, удирдлагыг сайжруулах, орлогыг үндэслэлтэй төлөвлөж, гүйцэтгэлд хяналт тавих, санхүүгийн тайланг иж бүрэн тайлагнах зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор С.Бат-Эрдэнэ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ч.Болд, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Сарансүх нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2023 оны 3 дугаар сарын 03-ны 01/245 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 34,255.6 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 342.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага нь дараах арга хэмжээг авч ажилласан байна. Үүнд:

ХНХС-ын 2022 оны Б/04, Б/05, Б/06 дугаар тушаалаар тус газрын 3 дэд даргыг албан тушаалаас чөлөөлсөн байна. Мөн ТӨБЗГ-ын 2022 оны 360 дугаар тогтоолоор байгууллагын эзэмшлийн 211.0 сая төгрөгийн балансын үнэтэй Toyota land cruiser 200 маркийн 2 автомашиныг Засгийн газрын авто бааз УТҮГ-т балансаас балансад шилжүүлсэн өгсөн байна.

Дээрх хуулийн хүрээнд дэд даргын орон тоог хассанаар цалингийн 26.0 сая төгрөгийн зардал хэмнэж, албан тушаалын автомашинтай холбоотой сэлбэг, шатахууны зардал хэмнэх нөхцөлийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн аудитын асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

1. ХХҮЕГ нь Шилэн дансны цахим хуудсанд 2 мэдээллийг хугацаа хоцроож, дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайлан хагас жилээр, хөрөнгийн болон урсгал зардалд туссан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, худалдан авах ажиллагааны тайлан, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл, ...төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн 118.5 сая төгрөгийн мэдээллийг тус тус байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.1.4, 6.3.6, 6.4.4, 6.4.8 дахь заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь тогтмол бүрэн мэдээлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

2.Харьяа байгууллагуудад илэрсэн нийцлийн аудитын асуудлаар нийт 2,318.1 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 1,066.7 сая төгрөгийн 14 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 1,251.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 19 зөвлөмжийг өгсөн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд харьяа газруудын санхүүгийн тайлангийн аудитаар хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох зарим заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийх завсрын аудитын хугацаанд байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван, эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,207.2 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 82.0 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгснийг 81.9 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	1,207,219.1	4	1,017,019.1	88.8
Зөвлөмж	4	81,983.8	3	74,070.9	75
Нийт дүн	8	1,289,202.9	7.0	1,091,090.0	81.9

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- ХХҮЕГ нь Засгийн газраас баталсан орон тооны хязгаарын хүрээнд бүтэц, орон тоог шинэчилсэн эсэхийг;
- ХХҮЕГ-ын авлагын дансны үлдэгдэлд олон жилийн насжилттай олон улсын байгууллага, гадаадын байгууллагад ажиллаж байсан Монгол Улсын иргэдийн нийгмийн даатгалын шимтгэлийг улсын төсөвт татан төвлөрүүлснээс үүссэн 7.7 сая төгрөгийн Сангийн яамнаас авах авлага одоог хүртэл барагдаагүйг дараагийн аудитаар дахин хянан үзэх болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 8,949.5 сая төгрөгийн 41 алдаа¹ илэрснээс аудитын явцад 8,796.7 сая төгрөгийн 35 алдааг залруулга хийлгэж, 152.8 сая төгрөгийн алдааг давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өгсөн.

Аудитаар нийт 1,399.3 сая төгрөгийн 70 зөрчил² илэрснээс, 21.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн 13 акт тогтоож, 186.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах 16 албан шаардлага хүргүүлж, 1,189.3 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 40 зөвлөмж өгч, 1.3 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн 1,399.3 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 342.6 сая төгрөгөөс өндөр тул **Хязгаарлалттай** дүгнэлт өгсөн.

5.1 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 35 төсвийн байгууллага, 1 ахмадын сан, нийт 36 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 33 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллагын санхүүгийн тайланг аудитын түүвэр хамруулсан байна. Харьяа 33 байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар нийт 2,012.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2,009.1 сая төгрөгийн 32 алдааг аудитын явцад залруулж, 21.8 сая төгрөгийн 13 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 65.4 сая төгрөгийн 14 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 140.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 40 зөвлөмжийг өгч, 1.3 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлсэн.

5.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 6,936.6 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 6,787.6 сая төгрөгийн 3 алдааг залруулга хийлгэж, 149.0 сая төгрөгийн алдааг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн. Үүнд:

- Санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд 113.9 сая төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийн зардлыг данс буруу ангилж бүртгэснийг;
- Худалдан авсан 9.9 сая төгрөгийн вирусийн эсрэг программыг бараа материалын орлогоор бүртгээгүйг;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд нийт зардлын төлөвлөгөөг 6,663.8 сая төгрөгөөр илүү тайлагнасныг залрууллаа.

Аудитаар нийт 1,174.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 121.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлж, 1,053.1 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсөн.

5.2.1 Албан шаардлага

1. Жилийн эцсийн санхүүгийн тайланд өмнөх оноос шилжин ирсэн ажиллагсадтай холбоотой 0.2 сая, ажлаас үндэслэлгүй халагдсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон албан хаагчид олгосон цалин, НДШ-ийн нөхөн төлбөрийг байгууллагаас төлүүлснийг буруу

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан шийдвэр гаргасан албан тушаалтнаас авах 12.9 сая, нийт 13.1 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж, он дамжсан авлага үүсгэхгүй байх, авлагын үлдэгдлийг барагдуулах талаар албан шаардлага өгөв.

2. Засгийн газрын агентлагийн орон тооны хязгаар батлах тухай 2016 оны 4 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар (Засгийн газрын 2018 оны 110, 2019 оны 278 дугаар тогтоолоор тус тус өөрчилсөн) тус агентлагийн орон тооны дээд хязгаарыг 70 байхаар тогтоосон боловч уг үндсэн орон тооны хязгаарт жолооч, харуул, үйлчлэгч зэрэг төрийн үйлчилгээний 10 орон тоо батлагдаагүйгээс цалин, НДШ-ийн зардлыг байр ашиглалтын үйлчилгээ зориулалт арга хэмжээний зардлаар төлөвлөж, төсвийг батлуулж ирсэн зөрчлийг арилгах албан шаардлагыг 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгснийг хэрэгжүүлээгүй байна. Дээрх зөрчлөөр тайлант онд 108.3 сая төгрөгийн цалин, НДШ-ийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Энэ нь Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.4 "батлагдсан төсөв, сайдын баталсан зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарт багтаан агентлагийн орон тоо, цалингийн санг тогтоох", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 22 дугаар зүйлийн 22.6.3 "төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналыг төсвийн ангиллын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангиллын дагуу бэлтгэх" гэж заасныг болон Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалын 6 дугаар хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар", 2015 оны 7 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал"-ын холбогдох заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ХХҮЕГ-ын 2024 оны төсвийн төсөлд орон тооны хязгаарыг баримтлан төсөвт зардлыг холбогдох эдийн засгийн ангиллын дагуу зөв төлөвлөх талаар албан шаардлага өгөв.

5.2.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Нийгмийн халамжийн сангийн эх үүсвэрээр бэлтгэсэн 149.0 сая төгрөгийн ном, гарын авлага, плакат зэргийг бараа материалын тайланд орлогоор бүртгэхдээ тоо, ширхэг нэр төрлөөр нь ангилж бүртгээгүйгээс зарлагыг бодит гүйцэтгэл гарсан цаг хугацаа, тоо ширхгээр бус нийт дүнгээр нь журналд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2 "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Ном, гарын авлага тараах материалыг холбогдох анхан шатны баримтыг үндэслэн тоо, ширхэг нэр төрлөөр нь ангилан бараа материалын орлогоор бүртгэж, бодит гүйцэтгэлээр нь зардалд хүлээн зөвшөөрч бүртгэх, материалын үлдэгдэлд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: ХХҮЕГ-ын даргын 2022 оны А/279 дүгээр тушаалаар жилийн эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого хийх 8 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг томилж, тооллогыг гүйцэтгүүлсэн байна. Тооллогын тайлангаарх актын дүн нь санхүүгийн тайлангаарх үндсэн хөрөнгийн дүнгээс 378.4 сая төгрөгөөр дутуу, бараа материалын дүнгээс 245.0 сая төгрөгөөр илүү байгааг тооцоо бодож, санхүүгийн тайланд тохируулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-д "Тооллогын комисс дараах үүрэгтэй: 1/ эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах", 73 дугаар зүйлийн 73.2 "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай гүйцэтгэх, тооллогын актын дүн, дансны үлдэгдлийн дүнг тулгаж, тооцоо бодож байх.

3. Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Биет бус хөрөнгийн дансанд ашиглалтын хугацаа дууссан болон шинээр программ нэвтрүүлсэнтэй холбоотойгоор ашиглахаа больсон, 2016-2019 онд худалдан авсан 1,728.1 сая төгрөгийн анхны өртөгтэй 194.9 сая төгрөгийн үлдэх өртөгтэй 12 төрлийн программ хангамж бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ашиглахгүй байгаа программ хангамжийн ашиглалтыг сайжруулж, хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, цаашид ашиглах боломжгүй болсон программ хангамжийг актлах саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэх.

4. Орлогын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: ХХҮЕГ-ын харьяа 12 байгууллагын туслах үйл ажиллагааны төлөвлөсөн орлого 234.7 сая төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ: 41.2.1 "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, туслах үйл ажиллагааны орлогыг үндэслэлтэй төлөвлөх, гүйцэтгэлийг хангаж ажиллах.

5. Нягтлан бодох бүртгэл, бодлого, үйл ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: 2022 оны 5, 6, 7 дугаар сарын цалингийн тооцооны хүснэгтийг ХХҮЕГ-ын дарга болон ерөнхий нягтлан бодогчийн гарын үсгээр баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна" заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цалингийн тооцоо хүснэгтийг батлагдсан маягтын дагуу бэлтгэж, төсөв захирагчийн гарын үсгээр баталгаажуулж байх.

Илрүүлэлт: ХХҮЕГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг төрийн аудитын байгууллагад хүргүүлэхдээ төсвийн гүйцэтгэлийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "4.1.Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө", 4.1.3.Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан, "Санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлал", "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх" заавар, аргачлалын дагуу бэлтгээгүй, санхүүгийн тайлангийн Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн бэлтгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2022 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Шалгагдагч байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Зааруулсан		Зааруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
A	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	ХХҮЕГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлан	1	6,663,763.9			1	6,663,763.9	1	6,663,763.9				
2	ХХҮЕГ	4	272,860.0	1		3	272,860.0	2	123,820.9	2	149,039.1	2	149,039.1
3	БНСУ дахь ХНХҮТ	3	46,600.7			3	46,600.7	3	46,600.7				
4	Булган аймгийн ХХҮГ	1	0.0	1	0.0					1	0	1	
5	Говь-Алтай аймгийн ХХҮГ	1	5,892.7	1	5,892.7			1	5,892.7				
6	Говьсүмбэр аймгийн ХХҮГ	1	11,259.2			1	11,259.2	1	11,259.2				
7	Дархан-Уул аймгийн ХХҮГ	1	11,271.4			1	11,271.4	1	11,271.4				
8	Дорноговь аймгийн ХХҮГ	3	26,639.0			3	26,639.0	3	26,639.0				
9	Дундговь аймгийн ХХҮГ	1	29,353.2			1	29,353.2	1	29,353.2				
10	Орхон аймгийн аймгийн ХХҮГ	2	11,638.1	1	11,178.1	1	460.0	2	11,638.1				
11	Сэлэнгэ аймгийн ХХҮГ	1	2,480.0			1	2,480.0	1	2,480.0				
12	Сүхбаатар аймгийн ХХҮГ	3	3,819.9			3	3,819.9	0	0.0	3	3,819.9	3	3,819.9
13	Төв аймгийн аймгийн ХХҮГ	1	1,200.0			1	1,200.0	1	1,200.0				
14	Увс аймгийн аймгийн ХХҮГ	5	28,810.6			5	28,810.6	5	28,810.6				
15	Хэнтий аймгийн аймгийн ХХҮГ	1	2,387.5			1	2,387.5	1	2,387.5				
16	Хөвсгөл аймгийн аймгийн ХХҮГ	1	1,900.0			1	1,900.0	1	1,900.0				
17	Өмнөговь аймгийн ХХҮГ	1	3,528.5	1	3,528.5			1	3,528.5				
18	Нийслэлийн Хөдөлмөр халамжийн газар	4	1,619,787.0			4	1,619,787.0	4	1,619,787.0				
19	Багахангай дүүргийн ХХҮГ	1	340.0			1	340.0	1	340.0				
20	Сүхбаатар дүүргийн ХХҮГ	1	948.5			1	948.5	1	948.5				
21	Хан-Уул дүүргийн ХХҮГ	4	205,031.3			4	205,031.3	4	205,031.3				
	Нийт дүн	41	8,949,511.5	5	20,599.3	36	8,928,912.2	35	8,796,652.5	6	152,859.0	6	152,859.0

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

№	Шалгагдагч байгууллагын нэр	Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл										/Мянган төгрөгөөр/	
		Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
А	Б												
1	ХХҮЕГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлан	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	
2	ХХҮЕГ	1	234,740.5					1	234,740.5				
3	БНСУ дахь ХНХҮТ	5	939,817.7			2	121,491.8	3	818,325.9				
4	Баянөлгий аймгийн ХХҮГ	4	10,436.9	2	7,763.0	1	2,673.9	1					
5	Говь-Алтай аймгийн ХХҮГ	2	34,482.7					2	34,482.7				
6	Говьсүмбэр аймгийн ХХҮГ	7	29,033.3	2	5,845.0	5	23,188.3						
7	Дархан-Уул аймгийн ХХҮГ	1	262.3					1	262.3				
8	Дорнод аймгийн ХХҮГ	2	4,673.8	1	1,088.7			1	3,585.1				
10	Дорноговь аймгийн ХХҮГ	2	11,592.2	1	3,197.2	1	8,395.0						
11	Орхон аймгийн ХХҮГ	6	23,150.0			1	0.00	5	23,150.0				
12	Сэлэнгэ аймгийн ХХҮГ	4	3,508.9	1	588.0	2	2,553.5	1	367.4				
13	Сүхбаатар аймгийн ХХҮГ	3	7,149.1			2	7,149.1	1					
14	Ховд аймгийн ХХҮГ	1	284.7	1	284.7								
15	Хэнтий аймгийн ХХҮГ	3	150.0	1	150.0			2					
16	Хөвсгөл аймгийн ХХҮГ	1	1,286.3										
17	Өмнөговь аймгийн ХХҮГ	1	35,200.0							1		1,286.3	
18	Нийслэлийн Хөдөлмөр халамжийн газар	1	97.8	1	97.8			1	35,200.0				
19	Баянгол дүүргийн ХХҮГ	3	1,338.5					3	1,338.5				
20	Баянзүрх дүүргийн ХХҮГ	5	9,384.7					5	9,384.7				
21	Багануур дүүргийн ХХҮГ	2	12,065.2					2	12,065.2				
22	Багахангай дүүргийн ХХҮГ	2	2,190.7	1	210.7			1	1,980.0				
23	Сүхбаатар дүүргийн ХХҮГ	5	28,796.2			1	21,505.4	4	7,290.8				
24	Хан-Уул дүүргийн ХХҮГ	2	2,111.4					2	2,111.4				
25	Налайх дүүргийн ХХҮГ	5	6,397.3	2	2,561.9			3	3,835.4				
	Нийт дүн	2	1,143.3			1	0.0	1	1,143.3				
		70	1,399,293.5	13	21,787.0	16	186,957.0	40	1,189,263.2	1		1	1,286.3

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/Мянаан төгрөгөөр/

№	Шалгагддагч байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	B	1	2	3	4	5	6	7	8
1	ХХҮЕГ	1	118,520.0			1	118,520.0		
2	БНСУ дахь ХНХҮТ	4	219,842.4			2	17,753.0	2	202,089.4
3	Баянхонгор аймгийн ХХҮГ	1	-					1	
4	Булган аймгийн ХХҮГ	1	-			1			
5	Баянөлгий аймгийн ХХҮГ	1	11,612.6			1	11,612.6		
6	Говь-Алтай аймгийн ХХҮГ	3	-			1		2	
7	Говьсүмбэр аймгийн ХХҮГ	1	759.8					1	759.8
8	Дорнод аймгийн ХХҮГ	2	9,307.5			1	9,307.5	1	
9	Дорноговь аймгийн ХХҮГ	1	-			1	-		
10	Завхан аймгийн ХХҮГ	1	-					1	-
11	Орхон аймгийн ХХҮГ	1	-					1	-
12	Сэлэнгэ аймгийн ХХҮГ	2	-					2	-
13	Сүхбаатар аймгийн ХХҮГ	1	-					1	-
14	Төв аймгийн ХХҮГ	1	445,426.5					1	445,426.5
15	Ховд аймгийн ХХҮГ	1	3,000.0					1	3,000.0
16	Хэнтий аймгийн ХХҮГ	1	381,041.9			1	381,041.9		
17	Нийслэлийн Хөдөлмөр халамжийн газар	1	-					1	-
18	Баянгол дүүргийн ХХҮХ	1	40,866.0			1	40,866.0		
19	Баянзүрх дүүргийн ХХҮХ	1	41,244.0					1	41,244.0
20	Багануур дүүргийн ХХҮХ	1	-			1	-		
21	Батхандай дүүргийн ХХҮХ	1	302,413.8			1	302,413.8		
22	Сүхбаатар дүүргийн ХХҮХ	1	400,949.8					1	400,949.8
23	Сонгинохайрхан дүүргийн ХХҮХ	1	152,900.0					1	152,900.0
24	Хан-Уул дүүргийн ХХҮХ	1	167,407.9			1	167,407.9	0	-
25	Налайх дүүргийн ХХҮХ	1	17,787.1			1	17,787.1		
26	Чингэлтэй дүүргийн ХХҮХ	1	5,000.0					1	5,000.0
	Нийт дүн	33	2,318,079.3	0.00	0.00	14	1,066,709.8	19	1,251,369.5

СНАГ-2023/03/НА-СТА-ТТ3





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 24

№ 916/40160065

Улаанбаатар хот

СНАГ-2023/031-1А-СНА-ТБ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жилийн эцсийн санхүүгийн тайланд өмнөх оноос шилжин ирсэн ажиллагсадтай холбоотой 244,028.0 төгрөг, ажлаас үндэслэлгүй халагдсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон албан хаагчид олгосон цалин, НДШ-ийн нөхөн төлбөрийг байгууллагаас төлүүлснийг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаас авах 12,904,549.63 төгрөг, нийт 13,148,577.63 /арван гурван сая нэг зуун дөчин найман мянга таван зуун далан долоон төгрөг жаран гурван мөнгө/ төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, барагдуулах, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Бадрахбаяр, Төрийн захиргаа, санхүү удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Г.Оюун нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Ч.БОЛД

С.БАТ-ЭРДЭНЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 24

№ 714/АО/00065

Улаанбаатар хот

СНАГ-2023/03/НТ-00А-723

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засгийн газрын агентлагийн орон тооны хязгаар батлах тухай 2016 оны 4 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар (Засгийн газрын 2018 оны 110, 2019 оны 278 дугаар тогтоолоор тус тус өөрчилсөн) тус агентлагийн орон тооны дээд хязгаарыг 70 байхаар тогтоосон боловч уг үндсэн орон тооны хязгаарт жолооч, харуул, үйлчлэгч зэрэг 10 төрийн үйлчилгээний орон тоо батлуулаагүйгээс цалин, НДШ-ийн зардлыг байр ашиглалтын үйлчилгээ зориулалт арга хэмжээний зардлаар төлөвлөж, төсвийг батлуулж ирсэн зөрчлийг арилгах албан шаардлагыг 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгснийг хэрэгжүүлээгүй байна. Дээрх зөрчлөөр тайлант оны гүйцэтгэлээр 108,343,228.0 / Нэг зуун найман сая гурван зуун дөчин гурван мянга хоёр зуун хорин найм/ төгрөгийн цалин, НДШ-ийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Энэ нь Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.4 "батлагдсан төсөв, сайдын баталсан зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарт багтаан агентлагийн орон тоо, цалингийн санг тогтоох", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 22 дугаар зүйлийн 22.6.3 "төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналыг төсвийн ангиллын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангиллын дагуу бэлтгэх" гэж заасныг болон Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалын 6 дугаар хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар", 2015 оны 7 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал"-ын холбогдох заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. ХХҮЕГ-ын 2024 оны төсвийн төсөлд орон тооны хязгаарыг баримтлан төсөвт зардлыг холбогдох эдийн засгийн ангиллын дагуу зөв төлөвлөх, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Бадрахбаяр, Төрийн захиргаа, санхүү удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Г.Оюун нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Ч.БОЛД

С.БАТ-ЭРДЭНЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 24

№ 118/АМН/0065

Улаанбаатар хот

СНАГ - 2023/031-НА-СТА-013

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ХХҮЕГ нь Шилэн дансны цахим хуудсанд 2 мэдээллийг хугацаа хоцроож, дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайлан хагас жилээр, хөрөнгийн болон урсгал зардалд туссан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, худалдан авах ажиллагааны тайлан, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл, ...төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг зэрэг 118,520,000.00 / нэг зуун арван найман сая таван зуун хорин мянга/ төгрөгийн мэдээллийг тус тус байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.1.4, 6.3.6, 6.4.4, 6.4.8 дахь заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:


1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь тогтмол бүрэн мэдээлэх, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Бадрахбаярт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Ч.БОЛД

С.БАТ-ЭРДЭНЭ